



ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар #13

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар тушаалын тавдугаар хавсралтаар батлагдсан Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын эрх үүргийн 2.4 дэх хэсэг “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, аудитын албанд тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /Б.Буян-Ундрах/, аудитор /Д.Цогбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ



**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АУДИТЫН
ТОГТОЛЦОО, ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

ОРА-2021/15-ШТА-ГА



ДОТООД АУДИТЫН ТОГТОЛЦОО ХАРААХАН БҮРЭЛДЭЭГҮЙ БАЙНА.

Агуулга

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	1
Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл, үндсэн мэдээлэл.	2
Аудитын менежер: Б.Эрдэнэ	БҮЛЭГ 1. Дотоод аудитыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн байна.	4
Ахлах аудитор: Б.Буян-Ундрах	1.1 Дотоод аудитын эрх зүйн зохицуулалт хангалттай байна.	4
Аудитор: Д.Цогбадрах	1.1.1 Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгүүд хангалттай боловсруулагдан батлагдсан хэдий ч дотоод аудитын дүрмийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлээгүй байна.	4
2021 оны 10 дугаар сар	1.1.2 Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийг Засгийн газрын дүрэм шинэчлэн батлагдсанаас 2 жилийн дараа шинэчлэн баталсан байна.	5
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70357955, 70350757 дугаарын утас, 70359826 дугаарын факсаар харилцана уу.	1.2 Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломж бүрдэж байна.	6
Уг тайланг УАГ-ын веб сайтаас үзнэ үү. www.audit.mn	1.2.1 Дотоод аудитын сургалтад албан хаагчдын 57 хувийг хамруулсан байна.	6
Хаяг: Орхон аймаг дахь Төрийн аудитын газар	1.2.2. Хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байна.	8
Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон	1.2.3. Дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаагүй албан хаагчдыг томилон, ажиллуулж байсан байна.	9
	БҮЛЭГ.2 СХАА нь аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байна.	11
	2.1 Дотоод аудитын чиг үүргээсээ илүү санхүүгийн хяналт шалгалтад илүү анхаарч ажилласан байна.	11
	2.1.1 Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгээгүй байна.	13
	2.1.2 Нийт хяналт шалгалтын 25 хувийг дотоод аудит эзэлж байна.	14
	2.1.3 Дотоод аудитын нэгж үндсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлэхэд төлөвлөгөөт бус аудит нөлөөлж байна.	15
	2.1.4 Хяналт шалгалтын талаарх мэдээллийг өөрийн сайтаараа мэдээлсэн байна.	15
	2.1.5 Сангийн яам болон бусад аймгийн СХАА-тай уялдаа холбоотой ажиллаж байна.	15

2.2 Дотоод нэгжийн тогтоогдсон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрхэн нэгтгэж тайлагнах, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой журам байхгүй байна.	16
2.2.1 Эрх бүхий байгууллагаас чанарын хяналтыг 2 жил тутамд хийгээгүй байна.	16
2.2.2. Дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг бүрэн тооцож ажиллаагүй байна.	16
2.2.3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.	17
Аудитын дүгнэлт	18
Аудитын зөвлөмж	19
Холбогдох байгууллагын санал	20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУ	Монгол улс
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУМПХ	Олон Улсын Мэргэжлийн Практикийн Хүрээ
ДАОУМПХ	Дотоод аудитын олон улсын мэргэжлийн практикийн хүрээ
ДАОУИ	Дотоод аудитын олон улсын институт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 02 сарын 18-ны өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв батлах тухай”, 2021 оны 03 сарын 10-ны өдрийн А/28 тушаалаар батлагдсан аудитын төлөвлөгөөний дагуу, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх;
- Төрийн байгууллагууд дотоод аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Төрийн байгууллагуудын дотоод аудитын зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх Орхон аймгийн санхүү хяналт, аудитын албаны үйл ажиллагаанд Орхон аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС-300, 3000-3100), Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудиттай холбоотой дараах хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль,
- Захиргааны ерөнхий хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль,

- УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай”,
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”,
- Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”,
- Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн хяналт, шалгалтын стандарт”,
- Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”,
- Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийж гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах хянан удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Б.Буян-Ундрах, аудитор Д.Цогбадрах нар хийж гүйцэтгэв.

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын талбарын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 14-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн, тайланг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, Тэргүүлэх аудитораар баталгаажуулж, 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор УАГ болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор төсвийн ерөнхийлөн захирагч нарын Дотоод аудитын албыг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналт шалгалтын газартай нэгтгэн Сангийн яам, аймаг нийслэлийн Засаг даргын шууд удирдлагад шилжүүлсэн шийдвэр гарсан тул аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/587 дугаар захирамжаар аймгийн Дотоод аудитын албыг аймгийн Засаг даргын дэргэдэх “Санхүүгийн хяналт, аудитын алба” гэж өөрчлөн байгуулсан.

Аймгийн Засаг даргын 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/612 дугаар захирамжаар байгууллагын дүрэм, бүтэц орон тоо баталснаар “Санхүүгийн хяналт, аудитын алба” нэртэйгээр аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг болж байгуулагдсан байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо оновчтой эсэх.

Бүлэг 1 Дотоод аудитыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин бүрдсэн байна.

1.1 Дотоод аудитын эрх зүйн зохицуулалт хангалттай байна.

1.1.1 Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгүүд хангалттай боловсруулагдан батлагдсан хэдий ч дотоод аудитын дүрмийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолоор Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутагт төсвийн эрхийг шилжүүлэхтэй холбогдуулан улс, орон нутгийн төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын санхүүгийн хяналт, шалгалтын чиг үүргийг Сангийн яаманд шилжүүлсэн байна. Чиг үүрэг шилжсэнтэй холбогдуулан аймгийн мэргэжлийн хяналтын газрын санхүүгийн хяналт, шалгалтын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд шилжүүлжээ.

Сангийн яамны 2014 оны 10 сарын 30-ны өдрийн Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах талаар аймгийн Засаг дарга нарт хүргүүлсэн 10-1/5937 тоот албан бичигт Төсвийн тухай хуулийн хүрээнд Засаг даргын дэргэдэх “Дотоод аудитын алба” байгуулагдсан бол тухайн нэгжийн нэрийг “Санхүүгийн хяналт, аудитын алба” гэж өөрчлөх, хэрэв байгуулаагүй бол Засгийн газрын тогтоолын дагуу “Санхүүгийн хяналт, аудитын алба”-ыг шинээр байгуулж, зохион байгуулах талаар дурджээ.

Орхон аймгийн засаг даргын 2014 оны 11 сарын 19-ны өдрийн А/612 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, аудитын дүрэм, бүтэц орон тоог баталсан байна.

Монгол Улсын хуулиуд дахь дотоод аудиттай холбоотой заалтуудыг хүснэгтээр харуулбал:

Хууль журмын нэр	Хуулийн зүйл, заалт	Агуулга
Төрийн хяналт, шалгалтын тухай хууль	6.4-д	Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг Засгийн газар тогтооно.
	8.2.1-д	Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлэх;

Төсвийн тухай хууль	4.1.49-д	“Дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг;
	69.1-д	Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.
	69.2-д	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албыг үйл ажиллагааны стандарт, арга зүйн удирдлагаар хангана.
	69.3-д	Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.
	69.4-д	Дотоод аудитор нь санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрхтэй байна.
	69.5-д	Дотоод аудитын албаны дүрмийг Засгийн газар батална.

Дээрх хуулийн заалтуудад үндэслэн Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, 2015 оны 483 дугаар тогтоолоор “Дотоод аудитын дүрэм”, Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар “Улсын салбарын дотоод аудитын аргачлал” тус тус батлагдсан байна.

2015 оны 483 дугаар тушаалаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7 дахь хэсгийн 7.1-д “Дотоод аудитын нэгж нь тухайн жилийн болон дунд хугацааны төлөвлөгөөтэй байх бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч батална” гэж заасны дагуу СХАА-ыг 2015-2017 онд хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталсан байна. Гэсэн хэдий ч 2018 оноос хойш дунд хугацааны төлөвлөгөө батлагдаагүй байна.

СХАА нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дотоод аудитын стандарт /IPPF/, Сангийн сайдын 2015 оны 348 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын эрсдэлийн удирдлагад дотоод аудитыг нэвтрүүлэх заавар”, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын хорооны дүрэм”, 274 дүгээр тушаалаар батлагдсан “Дотоод аудитын чанарын үнэлгээний аргачлал” зэрэг эрх зүйн баримт бичгүүд мөрдөгдөж байна.

1.1.2 Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийг Засгийн газрын дүрэм шинэчлэн батлагдсанаас 2 жилийн дараа шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 1.1-д “Энэхүү дүрэм нь төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч бүрийн дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, зарчим, зохион байгуулалт, дотоод аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн эрх, үүргийг тодорхойлж, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагатай хамтарч ажиллахтай холбогдох харилцааг зохицуулна.”, 2.1-д “Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн

хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тус тус заажээ.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор “Аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1 дэх хэсгийн 1.4.2-т “Өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба харьяа байгууллага, аж ахуй нэгжид мөрдөх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг аймгийн Засаг дарга батална” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2014 оны А/612 дугаар захирамжаар “Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрэм”-ийг Засгийн газрын 2012 оны “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 129 дүгээр тогтоолыг үндэслэн баталсан байна.

Засгийн газрын 2012 оны “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 129 дүгээр тогтоолыг Засгийн газрын 2015 оны 483-р тогтоолоор хүчингүй болгосон. Тухайн тогтоол хүчингүй болж дүрэм шинэчлэгдээд 2 жил 5 сар өнгөрсний дараа аймгийн Санхүүгийн хяналт, аудитын дүрмийг Засаг даргын 2018 оны 04 сарын 20-ны өдрийн 233 дугаар захирамжаар шинэчлэн баталсан байна.

Шинэчлэн баталсан дүрэмд тус албаны удирдлага, зохион байгуулалт, бүтэц, үндсэн чиг үүрэг, дотоод аудиторын эрх, үүрэг, хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоо зэрэг ерөнхий шаардлагыг тусгасан байна.

Иймд Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийг Засгийн газрын дүрэм шинэчлэн батлагдсан тохиолдолд цаг алдалгүй шинэчлэн баталж байх талаар зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэх боломж бүрдэж байна.

1.2.1 Дотоод аудитын сургалтад албан хаагчдын 57 хувийг хамруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2014 оны А/612 дугаар захирамж, 2016 оны А/89 дүгээр захирамж, 2018 оны А/411 дүгээр захирамж, 2019 оны А/564 дүгээр захирамжуудаар Санхүүгийн хяналт, аудитын албаны бүтэц, орон тоог тус тус баталсан байна.

Д/д	Засаг даргын 2014 оны А/612 дугаар захирамж, Засаг даргын 2016 оны А/89 дүгээр захирамж		Засаг даргын 2018 оны А/411 дүгээр захирамж	
	Албан тушаалын нэр	Орон тоо	Албан тушаалын нэр	Орон тоо
1	Албаны дарга буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	1	Албаны дарга буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч	1
2	Албаны ахлах мэргэжилтэн-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	1	Албаны ахлах мэргэжилтэн-Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	1
3	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	4	Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч	3
4	Аудитор-шинжээч	1	Аудитор-шинжээч	2
5	Дотоод ажилтан шинжээч	1	Дотоод ажилтан шинжээч	1
6	Нягтлан бодогч	1	Нягтлан бодогч	1
Дүн		9	Дүн	9

Засаг даргын 2018 оны А/564 дугаар захирамжаар тус албаны үйл ажиллагааг дэмжих үүднээс хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтний 1 орон тоог нэмэгдүүлж баталсан байна.

Он	Аудиторууд улсын байцаагчийн эрх авсан байдал				Дотоод аудитын сургалтад хамрагдсан байдал			
	Эрх тэй	Эрхгүй	Нийт дотоод аудиторуудын тоо	Улсын байцаагчийн эзлэх хувь	Хамрагдсан	Хамрагдаагүй	Нийт дотоод аудиторуудын тоо	Сургалтад хамрагдсан аудиторуудын эзлэх хувь
2015	6	1	7	86%	0	7	7	0%
2016	6	2	8	75%	0	8	8	0%
2017	5	2	7	71%	4	3	7	57%
2018	6	2	8	75%	5	3	8	63%
2019	4	2	6	67%	5	1	6	83%
2020	4	3	7	57%	5	2	7	71%
2021	4	3	7	57%	4	3	7	57%

2015 онд Санхүүгийн хяналт, аудитын албаны дотоод аудиторуудын 86 хувь нь улсын байцаагчийн эрхтэй байсан бол 2021 онд 57 хувь болж буурсан байна.

2015, 2016 онуудад аудиторууд дотоод аудитын сургалтад хамрагдаагүй байсан бол 2017 оноос эхлэн сургалтад хамрагдаж, 2021 оны байдлаар аудиторуудын 57 хувь нь сургалтад хамрагдсан байна.

2021 оны байдлаарх мэргэжлийн байдлыг графикаар харуулбал:



2021 онд аудиторуудын 72 хувь нь нягтлан бодогч, 14 хувь нь эрх зүйч, үлдсэн 14 хувь нь эдийн засагч мэргэжилтэй байна.

Үүнээс үзэхэд СХАА-ны аудиторууд нь бүгд мэргэжлийн хүмүүс байна.

Хөрөнгө, санхүүжилтийн хэмжээг хүснэгтээр харуулбал:



2015 онд орон нутгийн төсвөөс 120,394.8 мянган төгрөгийн санхүүжилт авч байсан бол 2020 онд 179,484.2 мянган төгрөг болтлоо өсжээ.

Үндсэн хөрөнгийн хэмжээ 2015-2020 оны хооронд 10,768.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Дотоод аудитын нэгж чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд боломжтой хөрөнгө нөөцөөр хангагдсан байна.

1.2.2. Хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Аудитын хүрээнд СХАА-ны үйл ажиллагаатай холбоотойгоор албан хаагчдаас санал асуулга авсан.



Санал асуулгад оролцогчдын 87.5 хувь нь аудитыг хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн гэж үзсэн бол 12.5 хувь нь бүрдээгүй гэж хариулсан байна.

ДАМПОУС-д дотоод аудитын нэгжийн хараат бус байдал ба бодитой хандлагын талаарх дараах заалтууд байдаг. Үүнд:

1. **1100-Хараат бус байдал ба бодитой хандлага**- Дотоод аудитын нэгж хараат бус байх, дотоод аудиторуд ажлаа гүйцэтгэхдээ бодитой хандах ёстой.
2. **110-Зохион байгуулалтын хараат бус байдал** - Дотоод аудитын нэгжид үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх боломж олгож буй байгууллагын доторх тухайн түвшинд аудитын гүйцэтгэх удирдлага тайлагнах ёстой. Аудитыг гүйцэтгэх удирдлага дотоод аудитын нэгжийн зохион байгуулалтын хараат бус байдлыг зөвлөлд наад зах нь жил тутам нотолж байх ёстой
3. **1111-Зөвлөлтэй шууд харилцах** - Дотоод аудитын нэгжийн удирдлага зөвлөлтэй шууд харилцаж ажиллана.

Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ын 5.1-д “Хараат бус байдлыг хангахын тулд санхүүгийн хяналт шалгалт явуулж байгаа газрын зохион байгуулалт, эрх зүйн байдал хяналт шалгалт явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна”, 5.1.2-т “Хяналт шалгалтын байгууллагын дарга нь байцаагчийн бие даан хараат бус ажиллах тал дээр дэмжлэг үзүүлэх хариуцлагыг хүлээнэ”, 5.1.3-т “Хяналт шалгалтын байгууллагын үүрэг, зорилго, хариуцлагыг албан ёсоор баталж хуульчилсан байна” гэж тус тус заасан байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу ЗДТГ-ын бүтцэд хамаарахаар байгаа боловч СХАА-ыг бие даан үйл ажиллагаагаа явуулахаар зохион байгуулсан байна.

1.2.3. Дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаагүй албан хаагчдыг томилон, ажиллуулж байсан байна.

Боловсролын зэргийг графикаар харуулбал:



Дээрх графикаас харахад 2021 онд нийт дотоод аудиторудын 57 хувь нь магистрын зэрэгтэй, 43 хувь бакалаврын зэрэгтэй байна.

Мэргэжлээрээ 5 жилээс доош жил ажилласан албан хаагчдыг хүснэгтээр харуулбал:

Томилогдсон огноо	Албан тушаал	Овог нэр	Мэргэжил	Мэргэжлээрээ ажилласан жил	Хяналт шалгалтын байгууллагад
2015	Ахлах мэргэжилтэн	Н.Ренчинханд	Нягтлан бодогч	2	0
2016	Дотоод аудитор	Т.Энхзаяа	Эдийн засагч	0	0

2015 онд мэргэжлээрээ 2 жил ажилласан хүнийг ахлах мэргэжилтний албан тушаалд, 2016 онд мэргэжлээрээ ажилласан ажлын туршлагагүй хүнийг дотоод аудиторын орон тоонд тус тус томилсон нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.4-д “Дотоод аудитор нь санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй, тухайн салбарт мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан,...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Орхон аймаг дахь
Төрийн аудитын
газар

Төрийн байгууллагуудын дотоод аудит чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж байна уу.

Бүлэг 2

СХАА нь аудитын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж чадахгүй байна.

2.1 Дотоод аудитын чиг үүргээсээ илүү санхүүгийн хяналт шалгалтад илүү анхаарч ажилласан байна.


2.1.1 Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь санхүүгийн хяналт шалгалт болон дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг байна. Үйл ажиллагаандаа санхүүгийн хяналт шалгалтын стандарт болон дотоод аудитын дүрмийг баримтлан ажиллаж байна.

Стандартаар¹ хяналт шалгалтад хамаарах төрийн захиргааны болон Засгийн газраас байгуулдаг бусад байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг тодорхой зааж, хяналт шалгалт хийх 9 чиглэлийг тодорхойлсон байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2015-2021 оны эхний хагас жилийн хооронд давхардсан тоогоор нийт 433 байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтыг графикаар харуулбал:




¹ Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг баталсан.


СХАА нь жилд дунджаар 60-аад байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт гүйцэтгэснээс 4 хүртэлх хувийг нь төлөвлөгөөт бус хяналт шалгалт эзэлж байна.

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-д дотоод аудитыг хэрхэн гүйцэтгэх үе шатны ажлуудыг нарийвчлан тусгасан байдаг. Мөн түүнчлэн нийцэл, гүйцэтгэл, санхүүгийн аудитыг гүйцэтгэх арга зүй, аудитад ашиглах загвар ажлын баримтыг багтаасан байдаг.

Аргачлалын 3 дугаар бүлэгт урьдчилан үнэлэх үе шатыг дараах алхмын дагуу хэрэгжүүлэхээр заасан байна.



Аудитын ажлын төлөвлөлтийг дараах алхмуудаас бүрдэнэ гэж заажээ.



СХАА-ны 7 жил хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтын ажлын баримтыг шалгахад аргачлалд заасан төлөвлөхийн өмнөх болон төлөвлөлтийн шатны баримт байхгүй байна. Үүнд

- Дотоод аудитын хэрэгцээ шаардлагын ойлгох;
- Мэдээллийг хэрхэн олж авч, шинжлэх;
- Шалгалтын цар хүрээг хэрхэн тодорхойлох;
- Байгууллагын засаглалын удирдлагыг үнэлэх;
- Байгууллагын дотоод хяналтыг үнэлэх;
- Эрсдэлийг тооцож, үнэлсэн байх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн эсэх нь тодорхойгүй, баримтжуулалт байхгүй байна.

Аудитыг төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгэх талаар зөвлөмж өгөхөөр болов.

Хамгийн их хяналт шалгалтад хамрагдсан байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэрс	2015	2016	2017	2018	2019	2020	СХШ	ДА
								2021	Нийт дүн
1	Баян-өндөр сумын сум хөгжүүлэх сан	1	1	2	1	1	1	1	8
2	Жаргалант сумын ЗДТГ	1	1	1	1	1	1	1	7

3	Жаргалант сумын сум хөгжүүлэх сан	1	1	1	1	1	1	1	7
7	Хот байгуулалт барилга захиалагчийн алба	1	1	1		1	1	1	6
8	Хот тохижуулах газар	1	1	1	1	1	1		6

Аудитад хамрагдах байгууллагыг ямар эрсдэлд үндэслэн, жил бүрийн төлөвлөгөөнд тусгаж байгаа нь тодорхойгүй байна.

Аймгийн ИТХ-ын ажлын алба болон сумдын ИТХ-ын ажлын албанд хяналт шалгалт хийсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

№	Байгууллагын нэрс	2015	2016	2017	2018	2019	2020	2021
1	Аймгийн ИТХ		1					
2	Жаргалант сумын ИТХ	1	1	1				1
3	Баян-Өндөр сумын ИТХ	1		1				1

Сумдын ИТХ-ын ажлын албанд 7 жилийн хугацаанд 3-4 удаа хяналт, шалгалт явуулсан бол аймгийн ИТХ-ын ажлын албанд 1 удаа хяналт, шалгалт хийсэн байна.

2.1.2 Нийт хяналт шалгалтын 25 хувийг дотоод аудит эзэлж байна.


ДАОУИ-ээс гаргасан ОУМПХ-д дотоод аудитыг байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан, бодитойгоор баталгаажуулах, зөвлөх үйл ажиллагаа ба системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж сайжруулахад туслах үүрэгтэй гэж тодорхойлсон.

2015 оноос 2021 оны эхний хагас жилийн байдлаарх дотоод хяналт шалгалтын нийт дүнд эзлэх хувийг хүснэгтээр харуулбал:

Он	Санхүүгийн хяналт, шалгалтын тоо	Дотоод хяналт шалгалт		Нийт тоо
		Тоо	Нийт дүнд эзлэх хувь	
2015	46	11		57
2016	57	10	15%	67
2017	67	3	4%	70
2018	33	21	39%	54
2019	36	18	33%	54
2020	38	23	38%	61
2021	48	22	31%	70
Нийт дүн	325	108	25%	433

Хүснэгтээс харахад 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор нийт 433 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийснээс 108 байгууллагад дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.

Нийт дүнд эзлэх дотоод аудитыг графикаар харуулбал:



СХАА-ны дотоод хяналт шалгалтын эзлэх хувь 2015 онд 19 хувь байсан бол 2021 онд 31 хувь болтлоо өссөн байна.

Нийт ажлын ихэнх хувийг санхүүгийн хяналт шалгалт эзэлж байна. Хуулиар тогтоосон эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэг орхигдох эрсдэлтэй.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн талаарх мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Огноо	Акт			Албан шаардлага	Зөвлөмж		Нийт зөрчил /мянган төгрөг/	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2015	33	28,021.55	32.0	69,272.53	38	-	103	97,294.1
2016	57	42,726.28	42	202,805.50	38	-	137	245,531.8
2017	64	29,450.50	46	105,934.20	102	-	212	135,384.70
2018	36	36,280.90	66	286,632.90	210	-	312	322,913.8
2019	27	45,570.30	60	207,310.80	236	-	323	252,881.1
2020	27	40,665.90	68	499,371.70	230	-	325	540,037.6
2021	14	6,970.10	24	183,101.90	88	-	126	190,072.0
Нийт дүн	258	229,685.54	338	1,554,429.53	942	-	1,538	1,784,115.07

Тогтоосон акт, албан шаардлагын үндэслэлийг авч үзэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Дотоод аудитын дүрмийг ерөнхий байдлаар тусгасан байна.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор нь ямар алдаа зөрчилд акт тогтоож, албан шаардлага, зөвлөмж өгөх нь тодорхойгүй, зохицуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

2.1.3 Дотоод аудитын нэгж үндсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлэхэд төлөвлөгөөт бус аудит нөлөөлж байна.

Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг шинэчлэн баталжээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2016 оны 03 сарын 04-ний өдрийн 20 дугаар тогтоолоор аудитын хороог байгуулсан байна.

Тухайн хорооны бүрэлдэхүүнийг 2019 онд болон 2021 онд шинэчлэн баталсан байна.

ДАМПОУС-д дотоод аудитыг төлөвлөхөд хоорондоо ялгаатай зорилго бүхий хоёр төрлийн төлөвлөгөөг ашигладаг ба энэ нь аудитын дунд хугацааны төлөвлөгөө болон жилийн төлөвлөгөөг ашиглахаар тусгасан.

Санхүү хяналт, дотоод аудитыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг 2018 оноос хойш батлаагүй байна.

Харин тухайн онд хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдах байгууллагын жагсаалтыг гаргаж, Засаг даргаар батлуулж байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Сангийн яамнаас ирүүлсэн нэгдсэн удирдамж, Засаг даргаас ирүүлсэн албан бичиг болон иргэн, аж ахуй нэгжээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу хийж гүйцэтгэсэн байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалт, дотоод аудитыг хийх нь албан хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, тухайн жилийн төлөвлөгөөт аудитын чанарт нөлөөлөх зэрэг үр дагаврыг дагуулж байна.

2.1.4 Хяналт шалгалтын талаарх мэдээллийг өөрийн сайтаараа мэдээлсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь үйл ажиллагааны талаарх мэдээллийг <http://sankhuu.orkhon.gov.mn/> сайтаараа дамжуулан олон нийтэд ил тод мэдээлж байна. Мөн зарим аудитын тайлан мэдээллийг орон нутгийн “Тусгал-TV”-тэй хамтран иргэд, олон нийтэд хүргэн ажиллажээ.

Сайтад мэдээлсэн мэдээллүүдийг үзэхэд жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, дотоод аудитын талаарх товч танилцуулга, цаг үеийн шинжтэй мэдээлэл, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг байршуулсан байна.

2.1.5 Сангийн яам болон бусад аймгийн СХАА-тай уялдаа холбоотой ажиллаж байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “дотоод аудитын дүрэм”-ийн 7.9-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь хагас, бүтэн жилийн тайлангаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт жил бүрийн 7 дугаар сарын 10-ны өдөр болон тухайн жилийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ” гэж заасны дагуу тайлан мэдээг цаг хугацаанд нь sankhuu_audit_mof@yahoo.com хаягаар хүргүүлэн ажилладаг байна.

Мөн 21 аймгийн СХАА-ны дарга нарын нэгдсэн чат группээр өөрсдийн санаа бодлоо хуваалцан мэдээлэл хүргэж, цаг алдахгүй хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаарх мэдээ, мэдээллийг солилцдог байна.

Дотоод аудитын дүрмийн 9 дэх хэсэгт дотоод аудитын нэгж нь төрийн аудитын байгууллагатай жилийн ажлын төлөвлөгөө, тайланг харилцан мэдээлэх, хамтарсан сургалт зохион байгуулах, арга зүй, туршлага, мэдээлэл харилцан судлах, солилцож хамтран ажиллаж болно гэж заасан ч Төрийн аудитын байгууллагатай хамран зохион байгуулсан ажил байхгүй байна.

2.2 Дотоод нэгжийн тогтоогдсон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрхэн нэгтгэж тайлагнах, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой журам байхгүй байна.

2.2.1 Эрх бүхий байгууллагаас чанарын хяналтыг 2 жил тутамд хийгээгүй байна.

Сангийн яамнаас 2017 онд СХАА-ны үйл ажиллагаанд дотоод аудитын чанарын үнэлгээ хийж, дүгнэлт өгсөн байна. Мөн 2021 онд Сангийн сайдын баталсан удирдамжийн дагуу дотоод аудитын чанарын үнэлгээ хийгдсэн боловч дүгнэлт хараахан гараагүй байна.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын үнэлгээг хоёр жилд нэг удаа хийнэ” гэж заасан байна.

Дотоод аудитын дүрэм батлагдсанаас хойш 6 жилийн хугацаанд 2 удаа чанарын үнэлгээ хийжээ.

2.2.2. Дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг бүрэн тооцож ажиллаагүй байна.

Дотоод аудитын дүрмийн 6.3.5-д “Дотоод аудитор буюу санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь шалгалтын дүнд тулгуурлан гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, зохих журмын дагуу биелэлтийг хангуулах арга хэмжээ авна”, 8.2-д “Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, нэг бүрчилсэн акт, албан шаардлага, аудитын зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний үе шат бүрийн явцын талаар зохих стандартын дагуу архивын нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгнө” тус тус заасан байна.

СХАА-ны 2015-2021 онд тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

(мянган төгрөг)

Огноо	Акт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хэрэгжилтийн хувь /дүнгээр/
2015	33	28,021.55	33	28,021.55	100%
2016	57	42,726.28	57	42,726.28	100%
2017	64	29,450.50	64	29,450.50	100%
2018	36	36,280.90	36	36,280.90	100%
2019	27	45,570.30	27	45,570.30	100%
2020	27	40,665.90	25	38,849.00	96%
Нийт дүн	258	222,715.44	242	220,898.54	99%

Дээрх мэдээллээс харахад 2020 оны 1,816.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн актаас бусад төлбөрийн акт бүрэн төлөгдсөн байна. .

СХАА-ны 2015-2021 онд тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

(мянган төгрөг)

Огноо	Албан шаардлага		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хэрэгжилтийн хувь /дүнгээр/
2015	32	69,272.53	32	69,272.53	100%
2016	42	202,805.50	42	202,805.50	100%
2017	46	105,934.20	46	105,934.20	100%
2018	66	286,632.90	66	286,632.90	100%
2019	60	207,310.80	51	175,234.30	85%
2020	68	499,371.70	57	421,105.90	84%
Нийт дүн	314	1,371,327.63	296	1,260,985.33	92%

Дээрх мэдээллээс харахад 2019 оны 32,076.5 мянган төгрөгийн 9 албан шаардлага, 2020 оны 78,265.8 мянган төгрөгийн 11 албан шаардлагаас бусад онуудын албан шаардлагын биелэлтийг 100 хувь тооцсон байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг аудитор бүр өөрсдөө хариуцдаг байна

Дотоод аудитын нэгжийн тогтоогдсон акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрхэн нэгтгэж тайлагнах, хэрэгжилтийг хэрхэн хангаж ажиллах талаар тодорхой журам байхгүйгээс албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг шалгадагч байгууллагын албан бичгээр хаадаг байна.

2.2.3. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.

Дотоод аудитын дүрмийн 2 дахь хэсгийн 2.1-т “Дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангаж тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж заасан.

СХАА 2015-2021 оны эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор 433 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж, 229,685.5 мянган төгрөгийн 258 ширхэг төлбөрийн акт тогтоож, 1,554,429.5 мянган төгрөгийн 338 ширхэг албан шаардлага, 942 зөвлөмж өгч ажилласан байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:


- Дотоод аудитын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичгүүд хангалттай боловсруулагдан батлагдсан хэдий ч дотоод аудитын дүрмийн зарим зүйл заалтыг хэрэгжүүлээгүй байна.
- Санхүүгийн хяналт, аудитын албаны дүрмийг Засгийн газрын дүрэм шинэчлэн батлагдсанаас 2 жилийн дараа шинэчлэн баталсан байна.
- Дотоод аудитын сургалтад албан хаагчдын 57 хувийг хамруулсан байна.
- Хөндлөнгийн нөлөөлөлгүй, хараат бусаар ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байна.
- Дотоод аудитын дүрэмд заасан шалгуурыг хангаагүй албан хаагчдыг томилон, ажиллуулж байсан байна.
- Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгээгүй байна.
- Нийт хяналт шалгалтын 25 хувийг дотоод аудит эзэлж байна.
- Дотоод аудитын нэгж үндсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлэхэд төлөвлөгөөт бус аудит нөлөөлж байна.
- Хяналт шалгалтын талаарх мэдээллийг өөрийн сайтаараа мэдээлсэн байна.
- Сангийн яам болон бусад аймгийн СХАА-тай уялдаа холбоотой ажиллаж байна.
- Эрх бүхий байгууллагаас чанарын хяналтыг 2 жил тутамд хийгээгүй байна.
- Дотоод аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг бүрэн тооцож ажиллаагүй байна.
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмрээ оруулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА С.БАТЖАРГАЛ ТАНАА:**

1. СХАА-ыг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг батлах.

**САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА
Д.САЙЗМАА ТАНАА:**

1. СХАА-ны дүрмийг Засгийн газрын дүрэм шинэчлэн батлагдсан тохиолдолд цаг алдалгүй шинэчлэн батлуулж байх.
2. Төлөвлөлтийн өмнөх болон төлөвлөлтийн шатны ажлыг холбогдох стандартад тусгасны дагуу хийж гүйцэтгэх.
3. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөө болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотоод аудит хийх, Төсвийн Ерөнхийлөн захирагчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой тусгаж хэрэгжүүлэх.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ОРХОН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

61029 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Зэст баг, Залуучуудын гудамж,
Захиргааны III байр, Утас/Факс: 70359856
Цахим шуудан: sankhuu_audit_or@yahoo.com

2021. 11. 06 № 194
танай 2021. 10.29-ны № 204 -т

Г ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН Г
АУДИТЫН ГАЗАРТ

Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан
төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Төрийн
байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг
үүргийн хэрэгжилт” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Саналгүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн
ажиллах болно.

ДАРГА



Д.САЙЗМАА

Б. Буян-Угирраг
Тайланг хавсралаа
Х/02

0993000403